



## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Ногдол ашгийн бодлого (Цаашид “Бодлого” гэх)-ын баримт бичгээр Иншүрко даатгал ХХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилахтай холбоотой шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс энэхүү бодлогыг баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

### ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:

2.1.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

2.1.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

2.1.3. компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.

2.2. ТУЗ нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд уг шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах ба энэ баримт бичгийн 2.1-т заасан нөхцөл хангагдсан байна.

2.3. Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг дагаж мөрдөнө.

2.4. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.

2.5. Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.6. ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтооходоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.

2.8. Ногдол ашиг тараасны дараа үлдэх ашгаас нийгмийн хариуцлага, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болно. Сан байгуулах, түүний хөрөнгийг захиран зарцуулах журмыг гүйцэтгэх удирдлага боловсруулж, ТУЗ-ийн тогтоолоор батална.

2.7. Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байршуулна.

### **ГУРАВ.ХАРИУЦЛАГА**

3.1. Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь тараагаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанийд учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

### **ДӨРӨВ.БУСАД**

4.1. Энэхүү Бодлогоор зохицуулагдаагүй асуудлыг тухайн асуудлын талаарх тусгайлан зохицуулсан холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар эсвэл компанийн ТҮЗ-ийн шийдвэрээр зохицуулна.

4.2. Энэхүү Бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд ТҮЗ-ийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулна.

---оо---